

**ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА Д.АЗЖАРГАЛЫН 2024 ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН,
МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС**

Байгууллагын нэр: Аймгийн Засаг даргын Тамгын газар

Нэгжийн нэр: Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ	Гүйцэтгэлийн түвшин	Нийт (70 оноо)
1	2	3	4
1.	Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	97.7	68.39

2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор)
1.	Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулдаг онлайн сургалтад хамрагдах	Нийт 5 удаа сургалтад хамрагдсан	15
2.	Салбарын шинэчлэн батлагдсан хууль, тогтоомжийг тухай бүр судалж ажлын бүтээмжийг дээшлүүлэх	Салбарын сайд нарын 10 албан даалгавар, 15 тушаал, УОК-ийн 1 албан даалгавар, 5 тогтоолтай танилцаж судлан, биелэлтийг хангуулсан	15
3.	Солонгос хэлний ахисан шатны сургалтад хамрагдах	Солонгос хэлний 3 сарын сургалтад цахимаар хамрагдсан.	15
Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний дундаж оноо			15

3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ

Д/д	Үзүүлэлт	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор)
1.	Хандлага, ёс зүй	15
2.	Удирдан зохион байгуулах	15
3.	Асуудал шийдвэрлэх	15
4.	Манлайлах	15
5.	Багаар ажиллах	15
6.	Харилцаа	15
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)		
7.	Мэргэжлийн ур чадвар 1.	
8.	Мэргэжлийн ур чадвар 2.	
9.	Мэргэжлийн ур чадвар 3.	
Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо		15

4. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт	68.39
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	15
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ	15
4.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт	-
Нийт оноо		98.39

Үнэлгээ өгсөн:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА

..... /Т.РЭНЧИНВАНЖИЛ/
.....
(огноо)



Үнэлгээтэй танилцаж,
зөвшөөрсөн:

ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА /Д.АЗЖАРГАЛ/

.....
(огноо)

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО,
ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТ

2024.12.11

№	Зорилт, арга хэмжээ	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин			Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
					Эхний хагас жил	Сүүлийн хагас жил	жилийн		
НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ									
1.1 Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлнэ.									
1.1.1	Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт орон нутагтай хамааралтай 2024 оны зорилт, арга хэмжээг хэрэгжүүлнэ.		Арга хэмжээний тоо	16	16	16		Хэлтсийн чиг үүрэгт хамаарах 16 арга хэмжээг 82%-ийн биелэлттэй хэрэгжүүлсэн.	100
1.1.2	Завхан аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2024 оны зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангана.		Арга хэмжээний тоо	120		120		Хэлтсийн чиг үүрэгт хамаарах 120 арга хэмжээг 84.66%-ийн биелэлттэй хэрэгжүүлсэн.	100
1.1.3	Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2024 оны зорилт, арга хэмжээг хэрэгжүүлнэ.		Арга хэмжээний тоо	145	145	145		Хэлтсийн чиг үүрэгт хамаарах 145 арга хэмжээг 86.41%-ийн биелэлттэй хэрэгжүүлсэн.	100
1.1.4	Аймгийн 2024 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллана.		Арга хэмжээний тоо	188	188	188		Хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан 203 арга хэмжээний 87.78%-ийн биелэлттэй хэрэгжсэн.	100
1.2. Бичиг, жижиг, дунд үйлдвэрийг дэмжинэ									

1.2.1	Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжиж ЖДҮХС-с зээл олгоно.		Зээлийн хэмжээ	100%	Шалгуурын 1,5 тэрбум төгрөгийг зээлийг олгоно.	Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 12 аж ахуйн нэгж, 1 хоршоонд 1 тэрбум 485 сая төгрөгийн зээл олгосон.	90
1.2.2	Өрхүүдэд гэр бүлийн санхүүгийн боловсрол олгох сургалт сурталчилгааг нэмэгдүүлнэ.		Хамрагдсан малчин өрхийн тоо	1500	3000	Төсөл хөтөлбөрийн байгууллага, арилжааны банкуудтай хамтран нийт 1000 гаруй өрх, аж ахуйн нэгжүүдэд санхүүгийн боловсрол олгох сургалт, сурталчилгаа хийсэн. Гэр бүлийн санхүүгийн мэдлэг олгох контент, шторк бэлтгэн цахим сошиалаар сурталчилж 10000 гаруй иргэдэд хүргэсэн.	100
1.2.3	Улс, бүс, орон нутгийн үзэсгэлэн худалдаа зохион байгуулна.		Зохион байгуулагдсан үзэсгэлэн худалдааны тоо	3	1	"Цагаан сар-2024" үзэсгэлэн худалдааг 02 дугаар сарын 26-28-ны өдрүүдэд зохион байгуулж 7 аймгийн 110 гаруй аж ахуй нэгж бүтээгдэхүүн үйлчилгээгээ танилцуулж худалдаалсан. Ховд аймаг зохион байгуулагдсан "Мөнгөлөг шашуурга-2024" үзэсгэлэн худалдаанд Завхан аймгийг төлөөлөн 10 аж ахуй нэгж 30 гаруй төрлийн бараа бүтээгдэхүүнээр оролцож худалдан борлуулсан. Улиастай суманд "Алтан намар үзэсгэлэн худалдаа" зохион байгуулж 60 гаруй бизнес эрхлэгч, иргэн аж ахуй нэгж бараа бүтээгдэхүүнээ худалдан борлуулсан.	100
1.3	1.3. Байгалийн нөөцийг хамгаалан, нөхөн сэргээж, аялал жуулчлал, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлнэ.						
1.3.1	"Отонтэнгэр"-ийн аялал жуулчлалын мастер төлөвлөгөө боловсруулна.	ОНХС	Төлөвлөгөөний хэрэгжилт хувиар	0%		Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 10 дугаар тогтоолоор хасагдсан.	

1.3.2	Аялал жуулчлалын түнш аймгийн хүрээнд Монголын аялал жуулчлалын холбоотой хамтарч аялал жуулчлалын цогц арга хэмжээ хэрэгжүүлнэ	ОНХС	Төлөвлөгөөний хэрэгжилт хувиар	0	3 арга хэмжээ	5 арга хэмжээ	Улаанбаатар хотод зохион байгуулагдсан "Аялал жуулчлал- шинэлэг, чанартай үйлчилгээ B2B өдөрлөг", "Улаанбаатар травэл экспо"-д оролцож аяллын бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчилсан. Аймгийн аялал жуулчлалын салбарын зөвлөгөөн"-ийг зохион байгуулсан. Тэс сумд "Тэс сум- Арц суурь боомтын хөгжил 2024" олон улсын форумд ОХУ-ын Бүгд найрамдах Хакас улс, Тува улс, Кызыл хот, Эрзин мужын төлөөлөл оролцсон. Ай-Ти-Эм олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд Түнш аймгаар оролцож, салбарын 11 аж ахуйн нэгж давхардсан тоогоор 150 гаруй тур оператор компаниудтай 2025 онд жуулчлын хүлээн авах гэрээ байгуулсан. Хомын талын байгалийн цогцолборт газарт "Тусгай хамгаалалттай газар нутаг дахь нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлэх нь" хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Улиастай сумд аялал жуулчлалын зочлох үйлчилгээний төрөлжсөн сурталтыг аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж байгууллагын ажилтнуудад зохион байгуулсан.	100
1.3.3	Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд тарьц суулгац авна.	БХНС АХЗ	Тарьц суулгацын тоо	12600	8000-с доошгүй		Тарьц, суулгац нийлүүлэх ажлын гүйцэтгэгчээр "Отгон баян уул" ХХК шалгарч 2024 оны 05 дугаар сарын 07-ны өдөр улиас, бургас, шар хуайс, тэхийн шээг, монос, буйлс, гүйлс, голт борын 3 настай 9000 ширхэг суулгац нийлүүлсэн. Суулгацыг хаврын мод тариалтын хугацаанд Улиастай сумын 6 баг, 23 суманд хуваарилж айл өрхийн хашаанд тариулсан.	100
1.3.4	Тэмдэгжүүлэх самбар хийж байршуулна.	БХНС АХЗ	Тэмдэгжүүлсэн самбарын тоогоор	17	0	87	Сумдын усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсэд тэмдэгжүүлэх 40 ширхэг самбар хийх ажлыг "Хэм тех" ХХК-аар гүйцэтгүүлсэн.	70

1.3.5	Аймгийн бүх нутаг дэвсгэрт хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.	БХНС АХЗ	Бэлчээрийн ургамлын гарц хувиар	100	70 хувиас дээш		Цаг агаарын нөхцөл бүрдсэн үед хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагааг Завхан бороо экспедиц зохион байгуулсан. Нийт нутгаар бэлчээрийн ургамал цухуйлтын үе шат жигдэрч, ургамлын дундаж өндөр 4-11см, ургалтын байдал хэвийн буюу сайн үнэлгээтэй байна. Аймгийн хэмжээнд хуурайшилт 4 дүгээр сараас 5 дугаар сарын 31-нийг хүртлэх хугацаанд нийт нутгаар хуурайшилтын зэргийг 51 удаа бодож үнэлэхэд нийт нутгаар 31 өдөр их аюултай буюу нэн их аюултай (онц аюултай) зэргийн түвшинд хүрсэн.	100
1.3.6	Завхан аймгийн уур амьсгал, гадаргын усны нөөцийн 3D атлас гаргана.	БХНС АХЗ	Төлөвлөгөөний хэрэгжилт хувиар	70	90	100	Ус цаг уур орчны судалгаа мэдээллийн хүрээлэнтэй хамтран атласны судалгааны ажил хийгдэж, "Завхан аймгийн уур амьсгал, гадаргын усны нөөцийн атлас"-ыг 100 ширхэгийг хэвлэж салбарын байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн.	100
1.3.7	Аймгийн хэмжээнд хийгдэх татмын ойжуулалт болон ойн цэвэрлэгээний ажил хийнэ.	БХНС АХЗ	Ойжуулалт, ойн цэвэрлэгээ хийсэн талбайн хэмжээгээр	210	500	900	Алдархаан, Улиастай сумдад 77 га талбайд "Отгонбаян уул" ХХК, Цагаанхайрхан суманд 20 га талбайд "Хавчгийн ногоон мод" ХХК, Баянтэс суманд 10 га талбайд "Шилмүүст хангай" ХХК, Тэс суманд 10 га талбайд "Шилмүүст хангай" ХХК, Тэлмэн суманд 20 га талбайд "Тэнгэрлэг ой" ХХК нийт 137 га талбайд татмын ойжуулалт хийж нийт 109600 ширхэг мод тарьж, хүлээлгэн өгсөн.	100
1.3.8	Зэрлэг амьтны амьдрах орчныг тэтгэх биотехникийн арга хэмжээг хэрэгжүүлнэ.	БХНС АХЗ	Биотехникийн арга хэмжээ авсан цэгийн тоо	16	10	10	Идэр, Их-Уул, Сантмаргаз, Тосонцэнгэл, Тэлмэн, Ургамал, Цэцэн-Уул, Шилүүстэй, Эрдэнэхайрхан сумдад зэрлэг амьтны амьдрах орчныг тэтгэж 120 боодол өвс, 200 кг хужир тавих ажлыг зохион байгуулсан.Үлдэгдэл нөөцийг өвөлжилт хүндэрсэн үед хэрэглэхээр нөөцөлсөн.	100
1.4. Бэлчээрийн даацад нийцсэн ашиг шим өндөртэй эрүүл малыг өсгөн, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээг өргөжүүлнэ.								
1.4.1	Улс, аймгийн аварга малчин шалгаруулж хүндэтгэл үзүүлнэ.	ОНХС	Малчдын тоо	107	90		Улсын хошой аварга малчин өрх -1, Улсын аварга малчин өрх-10 Улсын аварга тариаланч-2, аймгийн хошой аварга малчин өрх -10, аймгийн аварга малчин өрх 92, аймгийн аварга тариаланч-4 шалгарч, хүндэтгэл үзүүлсэн.	100

1.4.2	"ENSURE" төсөлтэй хамтарч ажиллана.	ОНХС, ТХ	Төлөвлөгөөний хэрэгжилт хувиар	100%	50%	100%	90	Тосонцэнгэл, Их-Уул сумдад "Хурга махлуулах ажил"-ыг эхлүүлсэн. Сум тус бүрт 200 эр хургатай эх хонийг тэжээхээр 4.4 тн тэжээл нийлүүлэн аргачлалын дагуу эх хонийг тэжээсэн. Хурганы жин дунджаар 6.5-7 кг-д хүрч тэжээггүй хурганаас 2-3 кг-аар илүү болсон. Их-Уул, Эрдэнэхайрхан сумдад 6 дугаар сарын 17-27-ны өдрүүдэд "Хонины ноос хяргах сургалт" зохион байгуулсан. Тосонцэнгэл суманд дайвар бүтээгдэхүүний цехийн барилгын зураг төсөл хийгдэж Худалдан авах ажиллагааны газарт 3 удаа тендер зарлагдсан гүйцэтгэгч шалгараагүй байна. 3 суманд хөв байгуулах ажлын гүйцэтгэгч шалгарч гэрээ байгуулагдсан.
1.4.3	Аймгийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлнэ.	ОНХС	Бэлтгэсэн өвс, тэжээл тн	115,2 тн		124 тн	100	Аймгийн аюулгүйн нөөцөд 105 тн хивэг, 69 тн тэжээлийн улаан буудай бүрдүүлсэн.
1.4.4	Мал амьтныг шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээнд хамруулна.	БӨХ	Хамрагдсан малын тоо	3717,1	3700		75.1	Шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх угалганд 1512.2 мянган толгой, туулгалтанд 1063.5 мянган толгой, боловсруулалтад 121.1 мянган толгой мал, гуурын боловсруулалтад 83.1 мянган мал хамрагдсан.
1.5. Улсын болон орон нутгийн авто замын арчлалтыг сайжруулж мэдээлэл холбооны хүртээмжийг нэмэгдүүлнэ.								
1.5.1	Авто замын сангийн хөрөнгөөр цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан нэн шаардлагатай хөрөнгө оруулалтыг хийнэ.	ОНЗС	Ажлын гүйцэтгэл хувиар	100%	100%		100	Орон нутгийн замын сангийн 526 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Арцсуурь боомтоос Сонгино сум хүртэлх авто замыг тэмдэгжүүлэх, Асгат сумын Боодогтын дөрөлжийн модон гүүрийг засварлах, Баянхайрхан сумын төв доторх авто замын засварлах, Их-Уул сумын Зарт багийн Гүнжийн хясааны авто замын засварлах, Улиастай сумын нийтийн эзэмшлийн зам талбайг засварлах, Нутгийн удирдлагын ордны баруун талын явган хүний зам хийх, Алтай-Улиастай чиглэлийн авто зам дагуу Цагаанхайрхан сумын нутаг дэвсгэрт 35 км замын 5 гуу жалтыг шороогоор дарж засварлах ажил хийгдсэн. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 8 байршилд хатуу хучилттай авто зогсоол, 15 байршилд 3.2 км явган болон дугуйн зам, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар Ургамал сумын урд Хүнгүйн голд 36 у/м төмөр карказан гүүр барьж хүлээлгэн өгсөн.

1.5.2	24 сумын ерөнхий боловсролын сургуулиудад "Итгэлтэй угас" байрлуулна.	ОНХС	Итгэлтэй угасны тоо	5	24	"Алдар жаргал" ХХК-тай гэрээ байгуулсан. Гэрээний дагуу ажил хийгдэж дууссан.	70
1.6. Дэд бүтэц, орон сууцны хангамжийг нэмэгдүүлж, иргэдийн ая тухтай ажиллаж амьдрах орчин нөхцөлийг сайжруулна.							
1.6.1	Газар ашиглалт, эзэмшилт, өмчлөлтийн ажлыг жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу зохион байгуулна.	БӨХ	Газар ашиглалт, эзэмшилт, өмчлөлтийн хувь	24 сум, 13%	24 сум, 13,5%	Аймгийн ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 96 дугаар тогтоолоор 2024 онд иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ, байршлын батлуулж, аймгийн хэмжээнд шинээр өмчлүүлэх 208 иргэнд 21.353 га, эзэмшиж буй хашааны газраа өмчлөх 109 иргэнд 9,52 га, гэр бүлийн хэрэгцээнд шинээр өмчлүүлэх 97 иргэнд 11,433 га газрыг тусгасан 2024 оны 541 тоот албан бичгээр Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газарт хүргүүлсэн. Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 18 дугаар тогтоолоор Тосонцэнгэл, Улиастай сумдад 34 нэгж талбарын 5,28 га газрын өмчлүүлэхээр батлагдаж ирсэн ба бусад сумдын хотын хөгжлийн төлөвлөгөө хийгдээгүй гэдэг шалтгаанаар хасагдсан. 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн байдлаар нэгж талбарын тоон биелэлт 91.2, талбайн хэмжээ 90.0% хувьтай байна.	100

1.6.2	Барилга байгууламжийн ажлыг эхлүүлж, батлагдсан санхүүжилтэд багтааж угсралтын ажлыг хийнэ.	УТ, ОНХС	Барилга байгууламжийн тоо, ажлын гүйцэтгэл	40 барилга байгууламж, 00-30%	40 барилга байгууламж, 40-100%	Шинээр эхлэн баригдах 14, он дамнан баригдах 16, засвар шинэчлэлт хийгдэх 9, нийт 39 барилга байгууламжийн орон нутгаас шаардагдах зураг төсөл, ажлын тоо хэмжээг гаргаж, гүйцэтгэчийг сонгон шалгаруулах тендерийг зарлуулсан. Улиастай сумын Өлзийт багийн сургууль, цэцэрлэгийн барилгууд орон нутагт эрх шилжиж ирээгүй 2024 оны 02 сард БШУЯаманд ажлын зураг төсөл, төсөв, тоо хэмжээг хүргүүлэн, төрийн худалдан авах ажиллагааны газарт гүйцэтгэчийг сонгон шалгаруулах тендер зарлагдсан. Улиастай сумын Өлзийт багийн сургууль, цэцэрлэгийн барилгуудын гүйцэтгэгчээр "Ханжаргалант стоунс" ХХК 11 сард, "Баганат орд" ХХК 12 сард шалгарсан тул ажил хийх боломжгүй болсон. Орон нутагт эрх шилжиж ирсэн бусад шинээр эхлэн баригдах 12, он дамнан баригдах 16, засвар шинэчлэлт хийгдэх 9, нийт 37 барилгын ажил батлагдсан санхүүжилтэд багтааж газар шороо, суурь, карказ цутгалтын ажлууд хийгдсэн. 9 барилгын засварын ажлын гүйцэтгэгч шалгарч ажил хийж, 8 барилгын их засварын ажил хийгдэж, ашиглалтад орсон. Өвсний үндэс төсөл хөтөлбөрийн санхүүжилтээр хийгдэж байгаа Их-Уул сумын хүн эмнэлгийн барилгын засвар ажил 70%-тай хийгдэж байна. Энэ ажилд орон нутгаас шаардагдах бүх ажлуудыг хугацаанд нь хийж төсөл хөтөлбөрийн газарт хүргүүлсэн. Төсөл хөтөлбөрийн газарт гэрээ байгуулах ажил удааширсан тул хугацаа алдаж, 11 сард ажил эхэлсэн. Шинээр эхлэн баригдсан 5 барилга ажил дуусан ашиглалтад орсон.	100
1.6.3	Барилгын материалын сорилт шинжилгээний лабораторийг тоног төхөөрөмжөөр хангана	ТХ	Тоног төхөөрөмжийн тоо	4	10	Техник хяналтын зардал 20 сая төгрөгөөр Барилгын материалын сорилт шинжилгээний лабораторид компьютер тоног төхөөрөмж олгосон.	100

1.6.4	Сумдад халаалтын зуух, цэвэр ус, дулааны төвлөрсөн шугам сүлжээг эхлүүлнэ.	УТ, ОНХС	Ажлын гүйцэтгэлээр	10%	30%	50%	100	Дулааны станцын гадна шугам сүлжээний зураг төсөв хийгдэж "10 аймгийн Дулааны станц төсөл"-ийн нэгжид зураг төсвийг хүргүүлэн, тендер зарлагдаж, гүйцэтгэгч шалгарч, ажил эхэлсэн хийгдэж байна. Тосонцэнгэл сумын төвийн цэвэр усны худагаас 300м3, 500м3-ийн цэвэр усны сав хүртэлх хос шугам сүлжээг шинэчлэн хийж, цэвэр усны савны доторлогоог хийж, ус цэвэршүүлэгч суурилуулан ашиглалтад оруулсан. Улиастай сумын Өлзийт багийн үйлдвэрийн районы цэвэр усны 6.1км шугам сүлжээг тус тус хийж, 2024 онд батлагдсан санхүүжилтэд угсралтын ажлууд хийгдсэн.
1.6.5	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар он дамжиж хэрэгжиж буй зам барилгын ажлын явцад хяналт хийнэ.	УТ, ОНХС, ОНТ	Ажлын гүйцэтгэлээр	70%	Зам, барилгын ажил 100%-д хүрсэн байна.		100	Он дамнан баригдаж байгаа 16 барилгаас Асгат сумын дотуур байр, Отгон сумын спорт заал, Нөмрөг сумын соёлын төвийн барилга 2024 онд санхүүжилт батлагдаагүй тул ажил эхлээгүй, санхүүжилт батлагдсан 13 барилга 2024 оны батлагдсан санхүүжилтэд багтаан барилга угсралтын ажил 100% хийгдсэн. Цэцэн-Уул сумын дотуур байр, Баянхайрхан сумын цэцэрлэг, Түдэвтэй сумын соёлын төв, Идэр сумын 320 хүүхдийн сургууль, Шилүүстэй сумын ЗДТГ-ын барилга, нийт 5 барилга комисс ажиллаж, ашиглалтад хүлээн авсан. Улиастай сумын ХЖТеатр, Баянтэс сумын 320 хүүхдийн сургуулийн барилгууд энэ ондоо багтаж баригдаж дуусахаар 90%-тай гүйцэтгэж байна.
ХОЁР. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ								
2.1	Түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг хянаж шийдвэрлүүлэх	БӨХ	Хянаж шийдвэрлэсэн өргөдлийн тоо	3 өргөдөл 100%	1-ээс доошгүй	1-ээс доошгүй	100	Хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн 7 өргөдөл ирж, 4 өргөдлийг шийдвэрлэн, 3 өргөдлийг шийдвэрлэх боломжгүй талаар хуулийн заалт бүхий хариу хүргүүлсэн.

2.2	Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох боломжтой талбайн солбицлыг аймаг, сумдын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлж, аймгийн Засаг даргын саналыг Ашигт малтмал, газрын тосны газарт хүргүүлэх	БӨХ	Судалж, хүргүүлсэн саналын тоо	3 мэдэгдэл	1-ээс доошгүй	1-ээс доошгүй	Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох боломжтой мэдэгдэл Ашигт малтмал, газрын тосны газраас ирээгүй.	100
2.3	Барилга байгууламжийн ажлуудын техник эдийн засгийн үндэслэл, ажлын зураг төсөвт хяналт хийж, батална.	БӨХ	Зураг төсвийн тоо, хувь	50%	100%		Шинээр баригдах Эрдэнэхайрхан, Нөмрөг сумдад 100 хүүхдийн цэцэрлэг, Цагаанхайрхан сумын Соёлын төв, Сантмаргаз, Цагаанчулуут Эрүүл мэндийн төвийн барилга, аймгийн Архив, Музейн барилга зэрэг шинээр барих 15, их засаар шинэчлэлт хийх 5, нийт 20 барилга байгууламжийн зураг төсвийг хийлгэсэн	100
2.4	Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх аж ахуйн нэгжид зөвшөөрөл олгох, сунгах, цуцлах ажлыг зохион байгуулах	БӨХ	Шийдвэрлэсэн захирамжлалын тоо	2	4	4	Аймгийн Засаг даргын тусгай зөвшөөрөл олгох 7 удаагийн захирамжаар нийт 101 аж ахуй нэгжид согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгосон байна.	100
2.5	Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг боловсруулж, батлуулах ажлыг зохион байгуулна.	БӨХ	Гүйцэтгэл хувиар	100%	50%	100%	Аймгийн 2025 оны хөгжлийн төлөвлөгөөний төслийг Эдийн засаг, хөгжлийн сайдын 2023 оны 26 дугаар тушаалаар батлагдсан аргачлалын дагуу боловсруулж аймгийн ИТХ-ын 2024 оны 12-р сарын 02-ны өдрийн хурлаар батлуулсан.	100
2.6	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын ажлын саналыг боловсруулж харьяа төсвийн ерөнхийлөн захирагч нарт хүргүүлнэ.	БӨХ	Санал хүргүүлсэн төслийн тоо	74	20		Монгол Улсын 2025 оны төсвийн төсөлд тусгуулахаар зураг төсөл хийгдсэн 64 төсөл арга хэмжээний саналыг холбогдох материалын хамт Улсын төсвийн хөрөнгө оруулалтын цахим системээр харьяа төсвийн ерөнхийлөн захирагч нарт хуулийн хугацаанд хүргүүлсэн.	100
2.7	Тендерт шалгарсан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулна.	БӨХ	Байгуулсан гэрээний тоо	95	30	60	Тендерт шалгарсан болон шууд худалдан авалт хийх 119 төсөл арга хэмжээний гэрээ байгуулагдсан.	100

2.8	Орон нутгийн хөгжлийн индексийг тооцож Ldi.nda.gov.mn-д оруулж баталгаажуулна.	БӨХ	Индекс тооцсон сумын тоо	24	24	100
2.9	Орон нутгийн төсвийн хөрөнгө, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ажлын саналыг боловсруулж аймгийн ИТХ-ын хуралдаанаар батлуулна.	БӨХ	Гүйцэтгэл хувиар	30%	100%	100
2.1	Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлийг хянаж санхүүжилтийг олгоно.	БӨХ	Гүйцэтгэл хувиар	100%	100%	100
2.11	Уул уурхайн чиглэлээр төлөвлөгөөт болон, төлөвлөгөөт бус хяналтын ажлыг зохион байгуулна.	БӨХ	Төлөвлөгөөний хэрэгжилт хувиар	100%	100%	100

Орон нутгийн хөгжлийн индекс тооцох цахим системд 24 сумын мэдээллийг тооцон оруулж баталгаажуулсан.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 104 төсөл арга хэмжээг 17028.5 сая төгрөгөөр, орон нутгийн замын сангийн хөрөнгө оруулалтаар 6 төсөл арга хэмжээг 1218.0 сая төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 39 төсөл арга хэмжээг 6.4 тэрбум төгрөгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөж аймгийн ИТХ-ын 2024 оны 12-р сарын 02-ны өдрийн хурлаар батлуулсан.

Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээний гүйцэтгэлд хяналт тавин ОНХС-с 6.5 тэрбум төгрөг, ОНТ-өөс 7.6 тэрбум төгрөг, УТ-өөс 32,6 тэрбум төгрөгийн санхүүжилтыг бодит гүйцэтгэлээр олгосон.

2024 оны салбарын ерөнхий байцаагчийн баталсан удирдамжийн дагуу төлөвлөгөөт хяналт шалгалтаар Ургамал, Завханмандал, Дөрвөлжин сумдад үйл ажиллагаа явуулж буй ААН хяналт шалгалт хийсэн. Төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг 3 ААНБ-т хийсэн. 1.Засаг даргын захирамжаар Завханмандал сумын нутагт байрлах Шувуун хар уул ХХК-ны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн. 2.Завхан аймгийн прокурорын газраас шалгуулахаар ирүүлсэн тэсэр дэлбэрэх бодисыг холбогдох арга хэмжээг авч устгалын ажил зохион байгуулсан. 3.Засаг даргын захирамжийн хүрээнд Тосонцэнгэл суманд Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч Зостресорсиз ХХК-ны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн. Түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөлгүй олборлолт хийсэн 3 ААНБ-т зөрчил шалган шийдвэрлэх ажилгаа явуулж нийт 5 сая төгрөгийн торгуулийн арга авч ажилласан.

2.12	Мэдээлэл харилцаа холбооны чиглэлээр төлөвлөгөөт болон, төлөвлөгөөт бус хяналтын ажлыг зохион байгуулна.	БӨХ	Төлөвлөгөөний хэрэгжилт хувиар	100%	100%	100%	ЦХИХХЯамнаас баталсан 09-00/02 төлөвлөгөөт хяналт шалгалт хийх удирдамжийн хүрээнд 11 объектод, 09-00/06 урьдчилан сэргийлэх удирдамжийн хүрээнд 6 объектод, иргэн, аж ахуйн нэгж байгууллагын хүсэлтээр төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг 2 объектод тус тус хийж гүйцэтгэсэн. Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар улсын байцаагчийн 12 албан шаардлага, 4 зөвлөмж, 1 аж ахуйн нэгжид 2,753,000 төгрөгийн нөхөн төлбөр, 300,000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, бүрэн барагдуулан ажилласан.	100
2.13	Газрын тос, хийн хяналтын чиглэлээр төлөвлөгөөт болон, төлөвлөгөөт бус хяналтын ажлыг зохион байгуулна.	БӨХ	Төлөвлөгөөний хэрэгжилт хувиар	100%	100%	100%	Газрын тос, хийн хяналтын чиглэлээр 12 аж ахуй нэгж байгууллагт эрсдэлийн үнэлгээ хийж хяналт шалгалтын төлөвлөгөө боловсруулж, Салбарын хяналтын газрын улсын ерөнхий байцаагчийн баталсан удирдамжийн дагуу төлөвлөгөөт объектуудад хяналт шалгалт хийж илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах зорилгоор хугацаатай албан шаардлага хүргүүлж түүний хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллаа. Шувуун хар Уул ХХК-ийн байгууллагын ШТС нь ашиглалтын шаардлага хангахгүй байсан тул улсын ахлах байцаагчийн актаар зөрчлийг арилгах хүртэл түр үйл ажиллагааг нь зогсоосон. Их-Уул сумд үйл ажиллагаа явуулж буй шатахуун түгээх станцуудад төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж тэдгээрт борлуулагдаж буй шатахуунаас дээж авч хөдлөнгийн лабораторит шинжлүүлэхэд ямар нэгэн зөрчил илэрээгүй. Мөн Улиастай сумын Жаргаланд багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Петровис ХХК-ийн шатахуун түгээх станцын ойр орчимд хашаа барьж буй талаар ирүүлсэн албан бичгийн дагуу тухайн газарт очиж хэмжилт хийж үзэхэд галын аюулгүйн норм стандарт зөрчигдсөн байсан тул дүгнэлт хүргүүлж ажилласан	100

2.14	Авто тээврийн хяналтын чиглэлээр төлөвлөгөөт болон, төлөвлөгөөт бус хяналтын ажлыг зохион байгуулна.	БӨХ	Төлөвлөгөөний хэрэгжилт хувиар	100%	100%	100%	Зам тээврийн яамны салбарын хяналтын газраас ирүүлсэн 2024 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 04/02, 04/01, 2024 оны 02 дугаар сарын 15 -ны өдрийн 04/19 дугаартай удирдамжуудын дагуу автотээврийн чиглэлээр ажил, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагад төлөвлөгөөт 4, урьдчилан сэргийлэх 3, төлөвлөгөөт бус1 удаа шалгалт хийж, 2 байгууллагад ашиглагдаж байсан 2 нийтийн тээврийн хэрэгслийн үйл ажиллагааг улсын байцаагчийн актаар зогсоосон. Зам тээврийн яамнаас гаргасан зөвлөмж, сэрэмжлүүлэг, шторкийг олон нийтийн сүлжээнд хуваалцаж аж ахуйн нэгж, байгууллагад хүргүүлсэн.	100
2.15	Авто замын хяналтын чиглэлээр төлөвлөгөөт болон, төлөвлөгөөт бус хяналтын ажлыг зохион байгуулна.	БӨХ	Төлөвлөгөөний хэрэгжилт хувиар	100%	100%	100%	Авто замын хяналтын чиглэлээр 2024 онд 65 объектод эрсдэлийн үнэлгээ хийх хяналт шалгалтын төлөвлөгөөг салбарын хяналтын газарт хүргүүлж, 04/19, 04/04, 04/01 дугаар удирдамжуудын дагуу төлөвлөгөөт 10, төлөвлөгөөт бус 3, урьдчилан сэргийлэх 5 хяналт шалгалт хийж 3 аж ахуйн нэгжид зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн. Улсын байцаагчийн "Хууль тогтоомжийн хэрэгжилт хангах тухай" 26 заалт бүхий 5 албан шаардлага хүргүүлсэн. Гүүрийн ашиглалтын байдлын тухай 1 дүгнэлт, 3 зөвлөмжийг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн. Улсын болон орон нутгийн чанартай авто замаар ачаа тээвэрлэлт, зам, замын байгууламж, автотээврийн хэрэгслийн стандартын үзүүлэлтэд хяналт тавьсан.	100
ГУРАВ. ХУУЛИАР НИЙТЛЭГ ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ								
3.1	Аймгийн Засаг дарга, Засаг даргын орлогч, Тамгын газрын даргын үйл ажиллагаатай холбоотой мэдээ тайлан, илтгэлийг бэлтгэнэ.	БӨХ	Бэлтгэсэн мэдээ, тайлангийн тоо	6	8		Удирдлагыг мэдээлэлээр хангах зорилгоор салбарын 10 томоохон арга хэмжээ, зөвлөгөөний илтгэл мэдээллийг бэлтгэж өгсөн.	100
3.2	Байгууллага хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу баримт бичгийг бүрдүүлж, хадгаламж үүсгэнэ.	БӨХ	Хадгаламжийн нэгжийн тоо	10	10		Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу хадгаламжийн нэгжийг хугацаанд нь бичиг хэрэгт хүлээлгэн өгсөн.	100

3.3	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана.	БӨХ	Хугацаанд нь бүрэн нийтлэсэн байдал	100%	100%	100%	Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа ажлуудын санхүүжилтийн зарцуулалтын тайланг сар бүрийн 08-ны өдрийн дотор Shilendans.gov.mn сайтад байршуулж байна.	100
3.4	Хэлтсийн мэргэжилтнүүдийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж хэрэгжилтийг хангуулна	БӨХ	Үр дүнгийн үнэлгээний хувь	95%	90-с доошгүй хувь	90-с доошгүй хувь	Хэлтсийн 7 мэргэжилтэн, 5 байцаагчийн 1 дүгээр улиралын ажлыг дүгнэж, холбогдох урамшуулал олгуулсан. Хагас жил болон жилийн эцсийн ажлын гүйцэтгэлийн тайланг дүгнэж үнэлгээний багт хүргүүлсэн.	100
ДӨРӨВ. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САИЖРУУЛАХ ЗОРИЛТ								
4.1	Иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээн авч хугацаанд нь шийдвэрлүүлнэ	БӨХ	Шийдвэрлэсэн өргөдөл, гомдлын тоо, хувь	21 өргөдлийг 95% шийдвэрлэсэн	100%	100%	хэлтэст нийт 36 өргөдөл гомдол ирж 21 өргөдлийг хугацаанд нь барагдуулж, 5 өргөдөл шийдвэрлэх шатандаа байна.	100
4.2	Ойн мэргэжлийн байгууллагын тодорхойлолт гаргана	БӨХ	Гаргасан тодорхойлолтын тоо, хувь	53 хүсэлтийг 100% шийдвэрлэсэн	100%	100%	Ойн мэргэжлийн байгууллагын тодорхойлолт хүссэн өргөдөл ирээгүй болно.	
4.3	Барилга байгууламжийн ажлуудын техникийн нөхцлийг бүрдүүлж, архитектур төлөвлөлтийн даалгаварыг боловсруулна	БӨХ	Техникийн нөхцөл, архитектур төлөвлөлтийн даалгаварын тоо, хувь	50%	100%	100%	Шинээр баригдах Эрдэнэхайрхан, Нөмрөг сумдад 100 хүүхдийн цэцэрлэг, Цагаанхайрхан сумын Соёлын төв, Сантмаргаз, Цагаанчулуут Эрүүл мэндийн төвийн барилга, аймгийн төв номын сан, Музейн барилга зэрэг шинээр барих 15 барилга байгууламжийн техникийн нөхцөлийг бүрдүүлж, А даалгаварыг боловсруулан зураг төсөлийн ажлыг хийлтгэсэн.	100
ТАВ. НЭМЭЛТ АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ								
5.1	Аймгийн Засаг дарга, удирдлагуудаас өгсөн үүрэг даалгаврыг заасан хугацаанд нь хэрэгжүүлнэ.		Хэрэгжилтийн хувь, үүрэг даалгаврын тоо	100%	100%	100%	Аймгийн Засаг даргын Тамгын газарт нийт ирсэн бичгийн 43 орчим хувь буюу 2091 албан бичгийг шийдвэрлүүлсэн. Сард дунджаар 15-20 удаа удирдлагын нэмэлт үүрэг даалгаврыг хэрэгжүүлж байна.	100

5.2	Аймагас зохион байгуулсан нэгдсэн арга хэмжээ, хурал, зөвлөгөөнд бүрэн идэвхтэй оролцож, хэрэгжилтийг хангаж ажиллана.	Хурал, зөвлөгөөн болон нэгдсэн арга хэмжээнд хамрагдалтын хувь	100%	100%	100%	Аймгийн аварга малчин өрх шалгаруулж, хүндэтгэл үзүүлэх арга хэмжээ, Баруун бүсийн хоршоолочдын зөвлөгөөн, Аймгийн аялал жуулчлалын салбарын зөвлөгөөн, Тосонцэнгэл хөгжлийн гарц форум, Богд, Чигэстэй голын 290.03 у/м гүүрийн шав тавих ёслол, Алдарт эхийн одон гардуулах ёслол, Баруун бүсийн хоршоолочдын зөвлөгөөн, Хангайн бүсийн түншлэлийн форум-2024, Хүнсний хангамж, аюулгүй байдал-2024 арга хэмжээ, намрын мод тарих өдөр зэрэг томоохон арга хэмжээ зохион байгуулахад хэлтсийн албан хаагчид оролцсон.	100
5.3	Төрийн жинхэнэ болон төрийн үйлчилгээний албан хаагчид төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахих.	Ёс зүйн зөрчлийн тоогоор	-	Ёс зүйн зөрчилгүй ажилласан байна.	Ёс зүйн зөрчил гаргасан мэргэжилтэн, байцаагч байхгүй.	100	
5.4	Аймгийн Засаг даргын захирамжаар баталсан графикийн дагуу мэдээ тайланг хугацаанд нь үнэн зөв тайлагнана.	Хугацаанд нь хүргүүлсэн тайлангийн хувь	100%	100	100	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг 4 удаа хугацаа хоцорч, 3 удаа хугацаанд нь, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг 2 удаа хугацаа хоцорч, 3 удаа хугацаанд нь, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг 3 удаа хугацаанд нь 2 удаа хугацаа хоцорч цахимраар тайлагнасан болон Хөгжлийн жилийн төлөвлөгөөг 3 удаа хугацаанд нь тайлагнасан.	90
5.5	Егр.e-mongolia.mn төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн системийг хэрэгжүүлнэ.	Егр.e-mongolia.mn-ийг хэрэглэж хэвшинэ		Нэгдсэн системийг хэрэгжүүлж ажилласан байна.	Нэгдсэн системийг хэрэгжүүлж ажилласан байна.	Егр.e-mongolia.mn төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн системээр алба хаагчдын ирцийн бүртгэл, ирсэн бичиг, өргөдөл гомдлын бүртгэн, шилжүүлж хэвшсэн.	100
							97.70

Төлөвлөгөөг үнэлсэн:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

Т.РЭНЧИНВАНЖИЛ

2024 оны ... сарын ...-ны өдөр

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА

Н.БЯМБАДОРЖ

2024 оны ... сарын ...-ны өдөр

Тайлагнасан:

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын
хэлтсийн дарга

Д.АЗЖАРГАЛ

2024 оны ... сарын ...-ны өдөр

